



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламжийн бодлого

Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга Р.Гантуяа



ХҮҮХДИЙН ӨВЧЛӨЛ



Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, (Амбулатори) 2023 он

Үзүүлэлт	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Улаанбаатар	Орон нутаг	Улаанбаатар	Орон нутаг
Амьсгалын тогтолцооны өвчин	27.0	59.3	35.5	61.1
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	7.0	8.3	9.4	12.9
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	16.4	6.5	5.6	2.1
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	3.9	0.5	10.9	1.3
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	8.1	5.9	8.6	6.5
Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	5.7	5.3	4.2	4.8
Мэдрэлийн тогтолцооны өвчин	11.7	5.6	5.9	2.5



Тэргүүлэх шалтгаан

Хоёрдугаар шалтгаан

Гуравдугаар шалтгаан




ХҮҮХДИЙН ӨВЧЛӨЛ



Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, (Стационари) 2023 он

Үзүүлэлт	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Улаанбаатар	Орон нутаг	Улаанбаатар	Орон нутаг
Амьсгалын тогтолцооны өвчин	59.5	66.3	67.9	71.6
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	11.3	8.1	9.8	7.3
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	19.6	16.0	7.6	7.1
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	0.8	1.0	2.0	1.9
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	0.8	1.3	1.4	2.7
Төрөлхийн гажиг	1.3	0.2	1.4	0.2
Мэдрэлийн тогтолцооны өвчин	1.9	3.8	1.7	2.8





ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ



Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, хувь, 2023 он

Тэргүүлэх шалтгаан	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Улаанбаатар	Орон нутаг	Улаанбаатар	Орон нутаг
Мэдрэлийн тогтолцооны өвчин	0.9	2.8	2.4	5.2
Амьсгалын тогтолцооны өвчин	5.1	12.0	6.0	13.2
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	59.3	56.8	46.2	43.4
Төрөлхийн гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг	22.2	9.9	22.9	8.7
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	4.1	10.2	7.8	20.8

	Тэргүүлэх шалтгаан
	Хоёрдугаар шалтгаан
	Гуравдугаар шалтгаан



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ


ХҮҮХДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОР



Эрүүл мэндийн байгууллагын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний орны эзлэх хувь, тасгаар, 2023 он



Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний ор тасгаар	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв	Сум, тосгоны эмнэлэг	Хувийн эмнэлэг	Бусад эмнэлэг	Бүгд
Хүүхэд	10.6	11.1	13.9	29.0	23.0	2.9	14.8	13.4
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний ор ашиглалтын хувь, тасгаар, 2023 он



Эрүүл мэндийн үзүүлэлт 2023 он

2023-2024 онд Нийслэлийн хэмжээнд 16 эрүүл мэндийн байгууллагад томуу, томуу төст өвчний шалтгаанаар хэвтэн эмчлүүлж буй хүүхдийн статистик



Нийслэлийн хэмжээнд 16 эмнэлгийн 2299 орон дээр томуу, томуу төст өвчний шалтгаант хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс: Нийслэлийн харьяа 1412 ор, ЭМЯ болон бусад яамны харьяа эмнэлгийн 887 ор тус тус эзэлж байна. Томуугийн өвчлөл ихэссэнтэй холбоотой хүүхдийн нэмэлтээр дэлгэсэн ор 1249 байна.



Хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчний мэдээлэл

J02-04, J09-11, J12-18, J20, J31

Лавлагаа шатлалын
эмнэлэгт энэ
оношоор тусламж,
үйлчилгээ авсан
хүүхдийн тоо


148,566



6.4%

Анхан шатны
эрүүл мэндийн
байгууллагад
оношлуулсан
хүүхдийн тоо

9,487



32.4%

Хэвтүүлэх эмчлэх
тусламж, үйлчилгээ
авсан хүүхдийн тоо

48,205






ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

Хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчний ангилал



- Шууд лавлагаа шатлалд очсон хувь
- Анхан шатанд очсон хувь

Хүүхдийн тоо оношийн бүлгээр





Шатлал алгасах тохиолдол дундажаар **95 хувьтай** байна.




МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР


ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ЭРХЗҮЙН ОРЧИН






Вакцин хийлгэсэн хүүхдийн мэдээлэл



- Тусламж, үйчилгээ аваагүй хүүхдийн тоо
- Лавлагаа шатлалаас тусламж, үйлчилгээ авсан хүүхдийн тоо /2024/


Хүүхдийн дархлаажуулалтын мэдээлэл

Вакцин хийлгэсэн байдал /оношоор/



Нийт вакцины мэдээлэлд байгаа **756 мянган** хүүхдээс 2024 онд хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчлөлөөр лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ авсан **115 мянган** хүүхэд байна.

Томуу, томуу тест өвчнөөс бүх салбарт урьдчилан сэргийлэх



Хүүхдийн байгууллагад томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах арга хэмжээний зөвлөмж

Нэг. Ерөнхий мэдээлэл:

Дэлхий дахинд 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар А(Н3N2) вирус Төв Америк, Карибын тэнгисийн орнууд, Баруун Африкийн орнуудад, А(Н1N1)рdm09 вирус Өмнөд болон Зүүн Өмнөд Азийн улс орнуудад давамгайлан орчилд байгаа ба томуугийн идэвхжил нэмэгдсэн байна.

Манай улсад 2024 оны 38 дугаар долоо хоног буюу 09 дүгээр сарын 16-22-ны өдрүүдэд нийт 6,939 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлснээс 18.9%(1,312) нь амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай байсан ба өнгөрсөн оны мөн үеэс 3.9%-иар нэмэгдсэн байна. Амьсгалын замын цочмог хүнд халдвараар эмнэлэгт хэвтэгсдийн 78.9% нь 15 хүртэлх насанд, үүнээс 51.2% нь 5-аас доош насанд бүртгэгдсэн байна.

Томуу, томуу тест өвчний тархалтыг 5 түвшинд авч үздэг бөгөөд одоогийн байдлаар Монгол Улс 2-р түвшин буюу "Идэвхжлийн түвшин"-д байна. Үүсгэгчийн хувьд 38 дугаар долоо хоногт SARS-CoV-2 вирус болон риновирус, аденовирус, иж томуугийн вирус зэрэг олон вирус орчилд орж байгаа учраас хүн амын дундах амьсгалын замын өвчлөлийн үндсэн шалтгаан болж байна.

Цаашид томуу, томуу тест өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдвар ихсэх хандлагатай байгаа тул хүүхдийн байгууллагуудад дараах зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах арга хэмжээний зөвлөмж

1. Томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулахад эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж, дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх
2. Хүүхдийн байгууллагуудад ирцийн тандалтыг сайжруулж, ирээгүй хүүхдүүдийн шалтгааныг тодруулан бүртгэж, нэгтгэн, 7 хоног бүр аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт мэдээлэх;
3. Сургуулийн бага анги (1-6 анги) болон цэцэрлэгт ангийн багш, эмч хүүхдийг хүлээж авахдаа шинж, тэмдгийн тандалт хийж, ханиах, найтаах, нус гоожих гэх мэт томуу, томуу тест өвчин, амьсгалын замын халдварын шинж



Эрүүл мэндийн байгууллагуудад зориулсан томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах арга хэмжээний зөвлөмж

1. Ерөнхий мэдээлэл:

Дэлхий дахинд 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар А(Н3N2) вирус Төв Америк, Карибын тэнгисийн орнууд, Баруун Африкийн орнуудад, А(Н1N1)рdm09 вирус Өмнөд болон Зүүн Өмнөд Азийн улс орнуудад давамгайлан орчилд байгаа ба томуугийн идэвхжил нэмэгдсэн байна.

Манай улсад 2024 оны 38 дугаар долоо хоног буюу 09 дүгээр сарын 16-22-ны өдрүүдэд нийт 6,939 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлснээс 18.9%(1,312) нь амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай байсан ба өнгөрсөн оны мөн үеэс 3.9%-иар нэмэгдсэн байна. Амьсгалын замын цочмог хүнд халдвараар эмнэлэгт хэвтэгсдийн 78.9% нь 15 хүртэлх насанд, үүнээс 51.2% нь 5-аас доош насанд бүртгэгдсэн байна.

Томуу, томуу тест өвчний тархалтыг 5 түвшинд авч үздэг бөгөөд одоогийн байдлаар Монгол Улс 2-р түвшин буюу "Идэвхжлийн түвшин"-д байна. Үүсгэгчийн хувьд 38 дугаар долоо хоногт SARS-CoV-2 вирус болон риновирус, аденовирус, иж томуугийн вирус зэрэг олон вирус орчилд орж байгаа учраас хүн амын дундах амьсгалын замын өвчлөлийн үндсэн шалтгаан болж байна.

Цаашид томуу, томуу тест өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдвар ихсэх хандлагатай байгаа тул эрүүл мэндийн байгууллагууд дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

2. Амбулаторийн үзлэг, хүлээн авах хэсэгт хэрэгжүүлэх халдвараас сэргийлэх арга хэмжээ

- 2.1. Томуу, томуу тест өвчний (ТТӨ) халдвартай үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх эмнэлгийн ажилтан амны хаалт хэрэглэх;
- 2.2. ТТӨ-ий дэгдэлтийн улирлын үед амбулатори, яаралтай тусламж, хүлээн авахын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд заавал амны хаалт хэрэглэх;
- 2.3. ТТӨ-ий дэгдэлтийн үед үйлчлүүлэгч болон асран хамгаалагчид дараах арга хэмжээг зөвлөнө. Үүнд:
 - 2.3.1. Амьсгалын замын халдварын шинж тэмдэгтэй хүнээс 3 алхам буюу 1 метрийн зай барих;
 - 2.3.2. Амны хаалт зүүх, ханиах, найтаасан бол амны хаалтыг солих;
 - 2.3.3. Ханиах, найтаах үед сальфетка хэрэглэх, сальфетка байхгүй үед тохой руу найтаах;

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА Р.ГАНТУЯА

Томуу, томуу тест өвчний цаг үеийн байдал, авах арга хэмжээний талаар анхааруулга мэдээлэл өгөх цахим хурлын хөтөлбөр

Хэзээ: 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр 14:00 цагт

Цахим хурал: ZOOM ID: 219 827 7941 PASS: 202410


Цахим хуралд оролцогчид:

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газар, Нийгмийн Эрүүл мэндийн бодлогын газар, Салбарын хяналтын газар, Санхүү эдийн засгийн газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Нийслэлийн нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв

	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцагч
1.	Хурлын зорилго, хэлэлцэх асуудлын чиглэлийг танилцуулах	14:00-14:05	Р.Гантуяа, Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга
2.	Илтгэл: Томуу, томуу тест өвчний урьдчилан сэргийлэлт нөлөөллийн арга хэмжээ	14:05-14:15	Б.Мөнхзүл, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар, Халдварт өвчний хэлтсийн мэргэжилтэн
3.	Илтгэл: Томуу, томуу тест өвчний үеийн эрүүл мэндийн даатгалын санхүүжилт	14:15-14:30	Б.Оюунцэцэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга
4.	Илтгэл: "Хүүхдэд тохиолдох томуу, томуу тест өвчний эмнэлзүйн онцлог, эмчилгээний зарчим"	14:30-15:00	У.Цэвэгмид, Анагаах ухааны доктор, Дэд профессор, Хүүхдийн уушгины эмч, ЭМЯ-ны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвийн Эмчилгээ эрхэлсэн дэд захирал
5.	Илтгэл: Томуу, томуу тест өвчний тандалт, оношилгоо, эмчилгээ	15:00-15:25	П.Дэлгэрмаа, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Шинэ болон сэргэж байгаа халдварын тасгийн эрхлэгч
6.	Хурлыг хаах	15:25-15:30	Р.Гантуяа, Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга

Анхан шатан дээр багцын тусламж үзүүлэхэд гарах санхүүгийн нөлөө

Анхан шатны эдгэрэлтийн хувь



- Анхан шатандаа эдгэсэн хувь
- Лавлагаа дээр дахиж тусламж авсан хувь

Лавлагаа шатлал дээр хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчнөөр 2024 онд **148,566** хүүхэд тусламж, үйлчилгээ авсан ба нийт ЭМД-ын сангаас **32.9 тэрбум** төгрөгийн зардал гарсан байна.

Анхан шатанд хүүхдийн амьсгалын замын үрэвсэлт өвчний багцаар 2024 онд тусламж авсан **1,594** хүүхэд байгаа ба **78 хувь** нь лавлагаа шатлалд очоогүйгээр эдгэрсэн байна.

Өрх, сумын эрүүл мэндийн төвийн нөөцийг бүрдүүлж чадвал 148,566 хүүхдийн 78 хувийг өрх дээр бүрэн эдгээх боломжтой ба энэ нь **32.9 тэрбум** төгрөгийн зардлыг **16.5 тэрбум** төгрөг хүртэл бууруулах боломж харагдаж байна.



Анхан шатны ЭМБ-уудаас тусламж авч буй хувь

7%


Улсын дундаж

6.2%

Лавлагаа шатлалд тусламж, үйлчилгээ авахын өмнө анхан шатандаа нэг иргэнээр тусламж, үйлчилгээ авсан хүүхдийн хувиар **Өмнөговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар** гэсэн аймгууд тэргүүлж байна



Томуугийн хариу арга хэмжээний тогтолцооны шинэчлэл





ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Мэдээлэл, зөвлөгөөг боломжит бүх сувгаар идэвхижүүлэх, (зөвлөгөө өгөх-тусгай дугаар, утас)
- Тусламж, үйлчилгээний урсгал зохицуулалт хийх (халдварын сэргийлэлт, хяналт),
- Нэмэлтээр ажиллуулах хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, аппарат тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах,
- Эмнэлгийн орны төлөвлөлтийг өвчлөлийн хувиар тооцон хувилбартай хийж хэрэгжүүлэх,
- Томуугийн эмнэлзүйн удирдамжаар давтан сургалт зохион байгуулах,
- Бүх эмч, эмнэлгийн мэргэжилтэн томуугийн зөвлөмж өгч ажиллах (томуу-нүд, томуу-чих хамар, хоолой гэх мэт),
- Зөвлөгөө аваад гэрийн эмчилгээнд буцсан хүүхдийг эргэн хянах ажлыг зохион байгуулах, чанаржуулах,
- Аймаг, дүүргийн ЭМТ, НЭ, өрхийн эмнэлгийн ажлын уялдаа холбоог сайжруулах (ӨЭМТ-үүд эмнэлэгт хэвтээд гарсан хүүхдийн мэдээллийг өдөр бүр авч гэрийн хяналт хийх, чанаржуулах,)



**АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**